



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 12 дугаар сарын 09
№48 (1246)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠯᠢᠨ
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

923. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай Дугаар 75 3415

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

924. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 189 3416

925. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 190 3416

926. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 191 3417

927. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 192 3417

928. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 193 3418

929. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 194 3418

930. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 195 3419

931. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 196 3419

932. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 197 3420

933. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 198 3420

934. Анхан шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 199 3421

935. Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай Дугаар 201 3421

936. Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай Дугаар 202 3422



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 189

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 289 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Гантөмөрийн Урангууг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 190

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 278 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Доржбатын Шинэхүүг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 191

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 284 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Чадраагийн Баярсүрэнг Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 285 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Төрмөнхийн Ариунболдыг Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 279 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Буянжаргалын Сувд-Эрдэнийг Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 280 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Алтандөшийн Энхбаатарыг Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 195

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 283 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Дашбумбын Орхон тамирыг Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 196

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 286 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Амаржаргалын Цэлмэгийг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 197

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 288 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Болдын Баярсайханыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 198

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 287 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Ганхуягийн Батзаяаг Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 199

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 291 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Чинбатын Мөнхболорыг Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 201

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Катар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зоригтын Чинтүшигийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Катар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Пүрэвийн Сэргэлэнг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 202

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Ливан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чулууны Баярмөнхийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ливан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Энхтүвшингийн Булганыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 203

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 240 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Чойнорын Алтанцэцэгийг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 219

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 31.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2022 оны 219 дүгээр
тогтоолын хавсралт

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМААРАХ ЦАХИМ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх) нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг бүрдүүлэх, мэдээллийн сан үүсгэж, бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр.Мэдээллийг бүрдүүлэх

2.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах мэдээллийг дор дурдсан хугацаанд яаманд цахим хэлбэрээр хүргүүлнэ:

2.1.1.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг Төсвийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын төсөв батлагдсан болон төсвийн тодотгол хийгдсэнээс хойш 30 хоногийн дотор;

2.1.2.Засгийн газрын шугамаар авч ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг жил бүрийн эхний улиралд.

2.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5-д заасан байгууллага нь нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах энэ журмын 2.1-д зааснаас бусад цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг жил бүрийн эхний улиралд яаманд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.3.Энэ журмын 2.1, 2.2-т заасан мэдээллийг дараах жагсаалтын дагуу боловсруулна:

2.3.1.хэрэгжүүлэгч байгууллагын нэр;

2.3.2.төслийн нэр;

2.3.3.эхлэх хугацаа (он, сар, өдөр);

2.3.4.дуусах хугацаа (он, сар, өдөр);

2.3.5.санхүүжилтийн эх үүсвэр;

2.3.6.санхүүжилтийн төрөл;

2.3.7.санхүүжилтийн хэмжээ, валютын төрөл;

2.3.8.төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зорилго;

2.3.9.хамрах хүрээ;

2.3.10.хүлээгдэж байгаа үр дүн;

2.3.11. төсөл, хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийн тайлан.

Гурав.Мэдээллийн сан үүсгэж, бүртгэл хөтлөх

3.1.Яам нь энэ журмын 2.1, 2.2-т заасан мэдээллийг агуулсан санг бүрдүүлж хөтлөх бөгөөд уг сангийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангаж ажиллана.



3.2.Яам нь энэ журмын 2.1, 2.2-т заасан мэдээллийг ирүүлснээс хойш 7 хоногийн дотор мэдээллийн санд оруулна.

3.3.Энэ журмын 2.1, 2.2-т ирүүлсэн мэдээлэлд өөрчлөлт оруулсан талаар яаманд мэдэгдсэн тохиолдолд энэ талаарх өөрчлөлтийг мэдээллийн санд даруй оруулна.

3.4.Яам нь энэ журмын 2.1, 2.2-т заасан мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгон олон нийтэд ил байршуулна.

---ооо---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 6 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 230

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн 3 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн дагуу санхүүжүүлж, буцаан олголтын дутуу санхүүжилт болон 2022 оны 12 дугаар сарын санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

А.АРИУНЗАЯА

Засгийн газрын 2022 оны 230 дугаар
тогтоолын хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ БУЦААН ОЛГОХ,
БҮРТГЭХ, ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн дагуу 1,000,000 (нэг сая) ба түүнээс доош төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос албан журмаар болон сайн дураар даатгуулсан даатгуулагч (Монгол Улсын иргэн) (цаашид “даатгуулагч” гэх)-д өөрийнх нь 2022 оны 5-12 дугаар сард хариуцан төлсөн тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл (цаашид “нийгмийн даатгалын шимтгэл” гэх)-ийн 50 хувийг сар бүр буцаан олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

Хоёр.Хамрах хүрээ

2.1.Энэ журмын 1.1-д заасан буцаан олголт (цаашид “буцаан олголт” гэх)-ыг дор дурдсан даатгуулагчид олгоно:

2.1.1.нэг сая ба түүнээс доош төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн даатгалын санд шимтгэл төлсөн албан журмын даатгуулагч;

Тайлбар: хоёр ба түүнээс дээш ажил олгогчоос авсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэр нь нэг сая ба түүнээс доош төгрөг бөгөөд уг орлогоос тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн даатгалын санд шимтгэл төлсөн албан журмын даатгуулагчийг мөн тооцно.

2.1.2.нэг сая ба түүнээс доош төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд шимтгэл төлсөн сайн дурын даатгуулагч;

2.1.3.нэг сая ба түүнээс доош төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн

осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд шимтгэл төлсөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 2, 3-т заасан хүүхдээ гурван нас хүртэл асарч байгаа нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч эх.

2.2.Энэ журмын 2.1.2, 2.1.3-т заасан сайн дураар даатгуулагч нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан гэрээний дагуу нийгмийн даатгалын шимтгэлээ бүрэн төлсөн байна.

Гурав.Нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголтын хэмжээг тодорхойлох, олгох

3.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь даатгуулагчид олгох буцаан олголтын хэмжээг дараах тайлан, шимтгэлд үндэслэн тодорхойлно:

3.1.1.Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ажил олгогчоос нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэл болон мөн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлсэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан;

3.1.2.сайн дураар даатгуулагчийн Нийгмийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан гэрээний дагуу төлсөн шимтгэл.

3.2.Буцаан олголтыг дараах цаглаврын дагуу гүйцэтгэнэ:

3.2.1.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буцаан олголтын улсын төсвийн санхүүжилтийг нийгмийн даатгалын сангийн төсвийн хуваарийн дагуу сар бүрийн 10-ны өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлнэ;

3.2.2.нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 3.2.1-д заасан санхүүжилтийг сар бүрийн 15-ны өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нийгмийн даатгалын сангийн холбогдох харилцах дансанд шилжүүлнэ;

3.2.3.нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Монголбанкны “Автомат клиринг хаус системийн дүрэм”-д заасан шаардлагыг хангасан буцаан олголтод хамрагдах



даатгуулагчийн төлбөрийн мэдээллийг сар бүр гаргаж, дараа сарын 25-ны өдрийн дотор цахимаар болон албан бичгээр баталгаажуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн сангийн газар (цаашид “Төрийн сангийн газар” гэх)-т хүргүүлнэ;

3.2.4.Төрийн сангийн газар нь энэ журмын 3.2.3-т заасны дагуу ирүүлсэн мэдээллийн нийт мөнгөн дүн, тоо хэмжээ зөрчилгүй тохиолдолд банк хоорондын гүйлгээний боловсруулалтыг хийж, буцаан олголтыг даатгуулагчийн дансанд Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу шилжүүлнэ;

3.2.5.энэ журмын 3.2.3, 3.2.4-т заасан мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, нэгдмэл байдлыг холбогдох байгууллагууд тус тус хариуцна;

3.2.6.Төрийн сангийн газар нь буцаан олголтын гүйлгээ буцсан тохиолдолд Монголбанкны “Автомат клиринг хаус системийн дүрэм”-д заасны дагуу ажлын 3 хоногийн дотор төлбөр хийгдсэн (сангийн) дансанд шилжүүлнэ.

3.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 3.2.3-т заасан мэдээлэл, банкны дансны дугаарыг Монголбанкны дансны нэгдсэн системийг ашиглан шалгана.

3.4.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 3.2.4-т заасан даатгуулагчийн буцаан олголтод шилжүүлэх санхүүжилтийг Төрийн сан дахь нийгмийн даатгалын сангийн данснудаас нэг дансанд төвлөрүүлэн шилжүүлнэ.

3.5.Буцаан олголтын гүйлгээг банкны үйлчилгээний шимтгэл, хураамжаас чөлөөлнө.

3.6.Эрх бүхий байгууллагаас тогтоосон буцаан олголтын зөрүү даатгуулагчид олгох дараа сарын буцаан олголтоос суутган тооцож болно.

Дөрөв.Бүртгэх

4.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буцаан олголт авах даатгуулагчийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан гэрээнд үндэслэн тодорхойлж, цахимаар бүртгэнэ.

4.2.Энэ журмын 3.2.6-д заасны дагуу буцаан олголтын гүйлгээ буцсан тохиолдолд даатгуулагч нь нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем (e-barimt), төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia), нийгмийн даатгалын системээр дамжуулан цахимаар, эсхүл аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хандан холбогдох хүсэлтээ гаргаж, мэдээллээ бүртгүүлж болно.

Тав.Тайлагнах

5.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь буцаан олголтын тайлан, мэдээг сар бүрийн эцсийн өдрөөр тасалбар болгон Төсвийн тухай хуулийн 8.8, 8.9-д заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.2.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 5.1-д заасан тайлан, мэдээг Төсвийн тухай хуулийн 8.8, 8.9-д заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүр тооцоо нийлж, баталгаажуулна.

Зургаа.Хяналт тавих

6.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь буцаан олголт авах даатгуулагчийг тодорхойлох, бүртгэх, шимтгэл буцаан олгох үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

6.2.Худал мэдээлэх, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зэргээр даатгуулагчийн тоо, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын болон нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг үндэслэлгүй өөрчилсөн эсэхэд нийгмийн даатгалын байгууллага хяналт шалгалт хийж болно.

Долоо.Бусад

7.1.Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой заавар, түр хэрэглэх маягтын загварыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

7.2.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулах зорилгоор холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллана.



7.3.Буцаан олголттой холбоотой үүссэн бусад асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд холбогдох газрууд хамтран шийдвэрлэнэ.

7.4.Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 6 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 232

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем”-д тогтоосон хугацаанд байршуулж байхыг холбогдох байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ**

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2022 оны 232 дугаар
 тогтоолын хавсралт

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллага	Өгөгдлийн нэр	Нийтлэх хугацаа	
1.	Үндсэн хуулийн цэц	Нээлттэй хуралдааны тойм, мэдээ, мэдээлэл	Улирал бүр	
2.		Үйл ажиллагааны статистик мэдээлэл	Улирал бүр	
3.	Шүүхийн ерөнхий зөвлөл	Эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааны мэдээлэл	Хагас жилээр	
4.	Монгол Улсын Дээд шүүх	Үйл ажиллагааны статистик мэдээлэл	Хагас жилээр	
5.	Монгол Улсын Ерөнхий прокурор	Үйл ажиллагааны статистик мэдээлэл /Гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээллийн нээлттэй өгөгдөл/	Улирал, хагас жил, жилээр	
6.	Хүний эрхийн Үндэсний комисс	Сургалт, сурталчилгааны мэдээлэл	Улирал бүр	
7.		Хүний эрхийн судалгааны мэдээлэл	Улирал бүр	
8.		Хүний эрхийн Үндэсний комиссын зөвлөмж, санал, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн мэдээлэл	Улирал бүр	
9.		Комиссоос зохион байгуулсан хяналт шалгалтын тоо, хамрагдсан байгууллагын мэдээлэл	Улирал бүр	
10.		Комисст гаргасан өргөдөл, гомдлын мэдээлэл	Улирал бүр	
11.		Хүний эрхийн чиглэлээр өгсөн зөвлөгөө, мэдээлэл	Хагас жил, жилээр	
12.		"Хүний эрх" сэтгүүл	Хагас жил, жилээр	
13.		Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл	Жил бүр	
14.		Төрийн албаны зөвлөл	Төрийн албан хаагчийн нийт тоо	Жил бүр
15.			Төрийн албаны ангилал бүрд ажиллаж байгаа албан хаагчийн тоо	Жил бүр
16.	Төрийн албан хаагчийн тоо /төрийн албаны төрлөөр/		Жил бүр	
17.	Төрийн албан хаагчийн тоо /боловсролын түвшин, хүйсийн харьцаа/		Жил бүр	
18.	Төрийн албан хаагчийн тоо /насны бүлгээр/		Жил бүр	
19.	Төрийн албан хаагчийн тоо /хүйсийн харьцаа, төрийн албаны ангиллаар/, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт		Жил бүр	
20.	Нутаг дэвсгэрт хамаарах хүн амд ногдох төрийн албан хаагч, төрийн байгууллагын тоо		Жил бүр	
21.	Төрийн байгууллагын тоо /салбараар/, хамаарах албан хаагчийн тоо /хүйсийн харьцаагаар/		Жил бүр	
22.	Төрийн байгууллагын тоо /төрийн байгууллаар/, хамаарах албан хаагчийн тоо /төрийн албаны ангилал, хүйсээр/		Жил бүр	
23.	Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтад бүртгүүлж, шалгалтад тэнцэн нөөцөд бүртгэгдсэн иргэний тоо /хүйсээр/		Жил бүр	
24.	Тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа албан хаагчийн тоо /тэтгэврийн төрөл, төрийн албаны ангилал, төрлөөр/		Жил бүр	
25.	Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчийн тоо /хүйс, төрийн албаны ангилал, төрөл, насны бүлгээр/		Жил бүр	
26.	Төрийн албанаас тухайн онд түр чөлөөлөгдсөн албан хаагчдын тоо /хүйсийн харьцаа, төрийн албаны ангилал, төрөл, үндэслэлээр/		Жил бүр	



27.	Төрийн албанаас тухайн онд чөлөөлөгдсөн албан хаагчдын тоо /хүйсийн харьцаа, төрийн албаны ангилал, төрөл, үндэслэлээр/	Жил бүр
28.	Төрийн албанаас тухайн онд халагдсан албан хаагчдын тоо /хүйсийн харьцаа, төрийн албаны ангилал, төрөл, үндэслэлээр/	Жил бүр
29.	Төрийн улс төрийн албан тушаалтны тоо /төрлөөр/	Жил бүр
30.	Төрийн улс төрийн албан тушаалтны тоо /насны бүлгээр/	Жил бүр
31.	Сайд, дэд сайдын тоо /хүйсийн харьцаагаар/, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт	Жил бүр
32.	Аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарын тоо /хүйсийн харьцаагаар/, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт	Жил бүр
33.	Сум, дүүргийн Засаг дарга, Засаг даргын орлогч, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын тоо /хүйсийн харьцаагаар/, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт	Жил бүр
34.	Төрийн захиргааны албан тушаалын ангилал тус бүрд ажиллаж байгаа албан хаагчийн тоо /хүйсийн харьцаа/	Жил бүр
35.	Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн тоо /албан тушаалын төрлөөр/	Жил бүр
36.	Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн тоо /насны бүлэг, хүйсийн харьцаа/	Жил бүр
37.	Яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргаар ажиллаж байгаа албан тушаалтны тоо /хүйсийн харьцаа/, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт	Жил бүр
38.	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа албан тушаалтны тоо /хүйсийн харьцаагаар/, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт	Жил бүр
39.	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын даргаар ажиллаж байгаа албан тушаалтны тоо /хүйсийн харьцаагаар/, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт	Жил бүр
40.	Төрийн байгууллагын ангилал, төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн тоо /хүйсийн харьцаагаар/	Жил бүр
41.	Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн хүйсийн харьцаа /албан тушаалын ангиллаар/	Жил бүр
42.	Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн тоо /албан тушаалын төрлөөр/	Жил бүр
43.	Төрийн тусгай албанд ажиллаж байгаа албан хаагчийн тоо /насны бүлгээр/	Жил бүр
44.	Төрийн үйлчилгээний албан хаагчийн тоо /хүйсийн харьцаа, салбараар/	Жил бүр
45.	Төрийн үйлчилгээний албан хаагчийн тоо /албан тушаалын төрлөөр/	Жил бүр

46.		Төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн тоо /насны бүлэг, хүйсээр/	Жил бүр
47.		Төрийн байгууллагын ангилал, төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн тоо /хүйсийн харьцаагаар/	Жил бүр
48.		Тусгай шалгалт өгч төрийн албанд томилогдсон албан хаагчийн тоо	Жил бүр
49.	Жендэрийн үндэсний хороо	Жендэрийн сургагч багшийн тоо	Жил бүр
50.		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.3-т заасан "Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах" заалтын хэрэгжилтийн тоон мэдээ	Жил бүр
51.		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.1-д заасан "томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх" заалтын хэрэгжилтийн тоон мэдээ	Жил бүр
52.		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.2-т заасан "төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх" заалтын хэрэгжилтийн тоон мэдээ	Жил бүр
53.		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.2-т "Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс (цаашид "хороо" гэх) зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагад аль нэгэн хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байна" заалтын хэрэгжилтийн тоон мэдээ	Жил бүр
54.		Жендэрийн салбар зөвлөл, хорооны тоо	Жил бүр
55.		Жендэрийн салбар зөвлөл, хорооны дэд хөтөлбөрийн тоо	Жил бүр
56.	Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтний тоо	Жил бүр	
57.	Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байрны бэлгийн дарамтын талаар тусгасан байгууллагын тоо	Жил бүр	
58.	Цөмийн энергийн комисс	Цөмийн энергийн салбарт хэрэгжүүлсэн бодлогын судалгаа-хөгжүүлэлтийн тайлан	Жил бүр
59.		Дозиметрийн тохируулга, баталгаажуулалт	Хагас жилээр
60.		Цөмийн технологи, инновацын талаарх үндэсний болон олон улсын мэдээлэл	Хагас жилээр
61.		Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын технологи, зах зээл, төлөв байдлын талаарх үндэсний болон олон улсын мэдээлэл	Хагас жилээр
62.		Цөмийн эрчим хүчний технологи, зах зээл, төлөв байдлын талаарх мэдээлэл	Хагас жилээр
63.		Цагаатгагдсан иргэдийн мэдээлэл	Жил бүр
64.	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс	Нөхөх олговор олгосон иргэдийн мэдээлэл	Хагас жил, жилээр
65.		Сонинд нийтлэгдсэн иргэдийн мэдээлэл	Улирал бүр



66.	Сангийн яам	Аудит, хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн болон хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл	Улирал бүр
67.		Төсвийн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл /сая.төгрөг/	Жил бүр
68.		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүд, эдийн засгийн ангиллаар /хувиар/	Жил бүр
69.		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн объектын төрөл /тоо/	Жил бүр
70.		Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн мэдээлэл	Тухай бүр
71.		Тендерт оролцогчдоос тус яаманд гаргасан гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл	Сар бүр
72.		Засгийн газрын гадаад, дотоод ерийн мэдээлэл	Улирал бүр
73.		Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасны мэдээлэл	Улирал бүр
74.	Хууль зүй, дотоод хэргийн яам	Бүх сайдын захиргааны хэм хэмжээ тогтоосон тушаал	Сар бүр
75.		Засгийн газрын агентлагийн даргын захиргааны хэм хэмжээ тогтоосон тушаал	Сар бүр
76.		Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж	Сар бүр
77.		Зөвлөл, хороодын тогтоол	Сар бүр
78.		Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр	Сар бүр
79.		УИХ-аас томилогдсон байгууллагын даргын шийдвэр	Сар бүр
80.		Төрийн зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж буй байгууллагууд	Сар бүр
81.		Нотариатын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой мэдээлэл	Улирал бүр
82.		Галт зэвсэг импортлох, нийтэд худалдахтай холбоотой мэдээлэл	Улирал бүр
83.		Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл үйлдвэрлэхтэй холбоотой мэдээлэл	Улирал бүр
84.		Галт зэвсгийн сум үйлдвэрлэх, дахин цэнэглэхтэй холбоотой мэдээлэл	Улирал бүр
85.		Галт зэвсгийн сум импортлох, нийтэд худалдахтай холбоотой мэдээлэл	Улирал бүр
86.		Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой мэдээлэл	Улирал бүр
87.		Тамга, тэмдэг үйлдвэрлэхтэй холбоотой мэдээлэл	Улирал бүр
88.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчны мэдээллийн сангийн мэдээлэл	Тухай бүр
89.	Барилга, хот байгуулалтын яам	Тохирлын гэрчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл	Улирал бүр
90.		Технологийн заавар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл	Улирал бүр
91.		Сургалтад хамрагдсан инженер, техникийн ажилчдын статистик тоон мэдээлэл	Улирал бүр
92.		Улсын хэмжээнд ашиглалтад орсон орон сууцны статистик мэдээлэл	Хагас жил, жилээр
93.		Аймаг, нийслэлийн Сууц өмчлөгчдийн холбооны нэгдсэн бүртгэл, мэдээлэл	Хагас жил, жилээр
94.		Улсын хэмжээнд магадлалаар баталгаажсан зураг төслийн статистик тоон мэдээлэл	Хагас жил, жилээр
95.		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний статистик тоон мэдээлэл	Хагас жил, жилээр

96.	Боловсрол, шинжлэх ухааны яам	Боловсролын сургалтын байгууллагын тоо /улс, аймаг, орон нутгаар/	Жил бүр	
97.		Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан, хүний нөөцийн тоон мэдээлэл /улс, аймаг, орон нутаг, нас, хүйсээр/	Жил бүр	
98.		Боловсролын сургалтын байгууллагын сууралцагчийн тоон мэдээлэл /улс, аймаг, орон нутаг, нас, хүйсээр/	Жил бүр	
99.		Боловсролын сургалтын байгууллага төгсөгчийн мэдээлэл /суурь, бүрэн дунд боловсролын мэдээлэл улс, аймаг, орон нутгаар, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмшсэн мэргэжил, боловсролын түвшин/	Тухай бүр	
100.		Боловсролын сургалтын байгууллагын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээлэл /боловсролын түвшин бүрээр/	Жил бүр	
101.		Ерөнхий боловсролын сургуулийн улсын шалгалтын болон элсэлтийн ерөнхий шалгалтын дүн мэдээлэл /нэгтгэлээр/	Жил бүр	
102.		Зам, тээврийн хөгжлийн яам	Хот хоорондын зорчигч тээврийн мэдээллийн сангийн мэдээлэл	Өдөр бүр
103.			Автотээврийн техникийн хяналтын үзлэгт орсон автотээврийн хэрэгслийн тоон мэдээлэл, төрөл, марк, загвар	24 цагт, 7 хоног, сар, улирал, жилээр
104.			Техникийн хяналтын үзлэгт бүртгэгдсэн автотээврийн хэрэгслийн хорт утаа ялгаруулалтын хэмжээ /багц мэдээлэл/	Улирал бүр
105.			Техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй автотээврийн хэрэгслийн жагсаалт /сум, дүүргээр багц мэдээлэл/	Сар бүр
106.	Дотоодын ачаа тээврийн мэдээллийн сангийн мэдээлэл		Тухай бүр	
107.	Автотээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний түүх /багц мэдээлэл/		Тухай бүр	
108.	Бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн тоон мэдээлэл /төрөл, зориулалтаар/		24 цагт	
109.	Бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн насжилтын мэдээлэл /багц мэдээлэл/		Улирал бүр	
110.	Бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн тоо /түлшний төрлөөр, хүрдний байрлалаар, үйлдвэрлэгч улсаар/		Улирал бүр	
111.	Бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний тоон мэдээлэл		Улирал бүр	
112.	Бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн тоон мэдээлэл /марк, модель, модификаци бүрээр/	Тухай бүр		
113.	Бүртгэлтэй жолоочийн тоо, үнэмлэхийн ангилал, хүчинтэй хугацааны мэдээлэл	Тухай бүр		
114.	Тээврийн нэгдсэн систем буюу хот хоорондын ачаа тээврийн мэдээллийн системд бүртгэлтэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл, бүртгүүлэхээр хүсэлт өгсөн байгууллагын мэдээлэл	Улирал бүр		
115.	Автотээврийн хэрэгслийн "С" зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн жагсаалт	Улирал бүр		
116.	Тээвэрлэсэн ачааны тоо хэмжээ, төрөл, тээвэрлэсэн зайн талаарх мэдээлэл	Улирал бүр		
117.	Олон улсын, улсын, орон нутгийн чанартай, нийслэлийн, тусгай зориулалттай, хайрган хучилттай, сайжруулсан хөрсөн замын урт	Улирал бүр		
118.	Замын хөдөлгөөний эрчмийн мэдээлэл	Сар бүр		



119.		Авто замын төлбөр авах цэгүүдээр нэвтэрсэн автотээврийн хэрэгслийн тоо	Өдөр бүр
120.		Замын төлөвлөгөөний мэдээлэл	Тухай бүр
121.		Замын паспортын мэдээлэл	Тухай бүр
122.		Гүүрийн төлөвлөгөөний мэдээлэл	Тухай бүр
123.		Гүүрийн паспортын мэдээлэл	Тухай бүр
124.		Зам хариуцагчийн мэдээллийн жагсаалт буюу авто замын засвар, арчлалтын байгууллагуудын жагсаалт	Улирал бүр
125.		Вагон бүртгэлийн тоон мэдээлэл	Улирал бүр
126.		Төмөр замын урт, төмөр замын бүртгэлийн мэдээлэл	Улирал бүр
127.		Төмөр замын байгууламжийн бүртгэлийн мэдээлэл	Улирал бүр
128.		Салаа төмөр замын мэдээлэл	Улирал бүр
129.		“Улаанбаатар төмөр зам” ХНН, “Монголын төмөр зам” ТӨХК, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”-ийн мэдээллийн сангуудын төмөр замын ачаа тээврийн мэдээлэл	Өдөр бүр
130.		“Улаанбаатар төмөр зам” ХНН, “Монголын төмөр зам” ТӨХК, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”-ийн мэдээллийн сангуудын төмөр замын зорчигч тээврийн мэдээлэл	Өдөр бүр
131.		Зорчигч тээврийн статистик мэдээлэл	Сар бүр
132.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл	Сар бүр
133.		Газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдэл, нөөцийн мэдээ	Сар бүр
134.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаар зуучлагдсан иргэдийн тоо	Хагас жил, жилээр
135.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Мал хээлтүүлгийн мэдээлэл	3 дугаар сард 1 удаа
136.		Худгийн тоо, ашиглалтын мэдээлэл	1 дүгээр сард 1 удаа
137.		Мал төллөлт болон төл бойжилтын мэдээлэл	3, 4, 5, 6, 9 дүгээр сард 7 хоног бүр
138.		Бод малын зүй бус хорогдлын мэдээлэл	1-6, 9 дүгээр сард 7 хоног бүр
139.		Малын генетик нөөцийн мэдээлэл	2 дугаар сард 1 удаа
140.		Махны агуулахын мэдээлэл	6 дугаар сард 1 удаа
141.		Уринш элдэншүүлгийн мэдээлэл	6, 7, 8 дугаар сард 2 удаа
142.		Хөрс боловсруулалт, тариалалтад ажиллах техникийн бэлэн байдлын мэдээлэл	3, 4 дүгээр сард 1 удаа
143.		Хадланд ажиллах техникийн бэлэн байдлын мэдээлэл	6, 7 дугаар сард 1 удаа
144.		Ургац хураалтад ажиллах техникийн бэлэн байдлын мэдээлэл	7, 8 дугаар сард 1 удаа
145.		Бэлэн байгаа буудайн үрийн мэдээлэл	4, 12 дугаар сард 1 удаа
146.		Газар тариалангийн бүтээгдэхүүн хадгалах байгууламжийн мэдээлэл	9 дүгээр сард 1 удаа



147.		Ургамлын генетик нөөцийн мэдээлэл	2 дугаар сард 1 удаа
148.		Гадаадаас импортолсон үржлийн малын мэдээлэл /төрлөөр/	Улирал бүр
149.		Ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн малын тоо бүртгэл /төрлөөр/	Улирал бүр
150.		Малын үзлэг, ангилалтын мэдээлэл	Улирал бүр
151.		Удам зүйн үнэлгээнд хамрагдсан малын мэдээлэл /төрлөөр/	Улирал бүр
152.	Эрүүл мэндийн яам	Төрсөн эхийн тоо	Сар бүр
153.		Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлтөд/	Сар бүр
154.		Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/	Сар бүр
155.		Нас баралт /бодит тоогоор/	Сар бүр
156.		Халдварт өвчин 10 000 хүн амд	Сар бүр
157.	Эрчим хүчний яам	Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлт, борлуулалтын мэдээлэл	Сар бүр
158.	Эдийн засаг, хөгжлийн яам	Гадаад шууд хөрөнгө оруулалтын статистик тоон мэдээлэл	Хагас жил, жилээр
159.		Орон нутгийн хөгжлийн индекс /33 үзүүлэлт/	Жил бүр
160.		Аж үйлдвэрийн салбарын мэдээлэл	Жил бүр
161.		Үйлдвэрийн мэдээлэл	Жил бүр
162.		Үйлдвэрийн бүтээгдэхүүний мэдээлэл	Жил бүр
163.		Орон зайн мэдээлэл	Жил бүр
164.	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Бүх нийтийн үүргийн сангийн төсөл, арга хэмжээний бүртгэлийн мэдээлэл	Хагас жилээр
165.		Мэдээлэл хариуцагч суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах бүртгэлийн мэдээлэл	Хагас жилээр
166.		Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэлийн мэдээлэл	Хагас жилээр
167.		Суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, нээлттэй өгөгдлийн бүртгэлийн мэдээлэл	Хагас жилээр
